



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/251

Улаанбаатар хот

“Бодлогын судалгаа, шинжилгээний төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын эргэлтийн бус
хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд нийт 3,998,000.00 (гурван сая есөн зуун ерэн найман мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий иж бүрэн компьютерыг шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг “Бодлогын судалгаа, шинжилгээний төв” улсын төсөвт үйлдвэрийн газар (Р.Дагва)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ бүртгэн, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Ахлах нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн өмчийн харилцааны газрын
2024 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
М. дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Бодлогын судалгаа, шинжилгээний төв НТҮГ

№	Эд хогшлын нэр	Хэмжээ	Тоо ширхэг	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллага
1	Дэлгэц	ш	1	2022	1,599,000.00	1,599,000.00	419,300.00	1,179,700.00	Бодлогын судалгаа, шинжилгээний төв НТҮГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
2	Компьютер	ш	1	2022	2,399,000.00	2,399,000.00	2,305,000.00	94,000.00		
Тоног төхөөрөмжийн дүн						3,998,000.0	2,724,300.0	1,273,700.0		
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн						3,998,000.00	2,724,300.00			